

МЭДЭЭЛЭЛ

Төрийн ажил үйлчилгээг хариуцлагатай хэвийн шуурхай явуулж, үр дүнтэй ажиллах, хүний нөөцтэй холбоотой шийдвэр гаргахгүй байх талаар Төрийн албаны зөвлөлөөс чиглэл, үүрэг өгсөн албан бичгийг яамны харьяа 8 байгууллагад Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2017 оны 09 сарын 25-ны өдрийн 08 дугаартай албан тоотоор хүргүүллээ.

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 1033 дугаартай албан бичгийг хавсаргав.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДЭД

МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2017.09.18 № 1033
танай _____-ны № _____

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит бус чуулганы 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын ерөнхий сайд болон Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах шийдвэр гаргасан билээ.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх шатны төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг зохион байгуулах, төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах зарчмыг хэрэгжүүлэхэд мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй.

Иймд Засгийн газрыг шинэчлэн байгуулагдах хүртэл хугацаанд бүх шатны төрийн захиргааны байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийлгэхгүй байх арга хэмжээ авахыг зэрэгцээ төрийн албан хаагчдыг томилох, чөлөөлөх, халах, сэлгэх, шилжүүлэх зэрэг хүний нөөцтэй холбоотой шийдвэр гаргахгүй байх талаар эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч, төрийн ажил үйлчилгээг хэвийн шуурхай явуулж, хариуцлага, үр дүнг хангаж ажиллахыг үүрэг болгож байна.

ДАРГА



Б.ЦОГОО

